



Хураангуй

- Хөрсний ялзмаг, чийг шим тэжээлийн бодисын менежментийг цогцоор нь авч үзэх ёстой.
- Цулгүй уриншийг халж, таримлын сэлгээ, эзэнт уриншийг нэвтрүүлснээр хөрсний чийгийн хангамж буурахгүй, харин ч нэмэгдэх боломжтой.
- Таримлын сэлгээ, эзэнт уриншинд тэжээлийн ургамал, ялангуяа буурцагт таримал тариалснаар хөрсний үржил шим сайжирч, малын тэжээлийн хангамж нэмэгдэхийн сацуу тариаланчдад орлогын нэмэлт эх үүсвэр бий болно.
- Хөрс хамгаалах технологи нь хөрсний чийгийн алдагдлыг бууруулж, органик нүүрстөрөгчийн агууламжийг нэмэгдүүлдэг.
- Тариалангийн хөрс чийгээс гадна шим тэжээлийн хомсдолтой байна. Хөрсний шим тэжээлийн бодисын агууламжийн талаар баттай мэдээллийн бааз бүрдүүлж, хөрсийг хэрэгцээтэй хэмжээгээр нь бордох шаардлагатай.
- Монголын тариаланчид “нүүрстөрөгчийн тариаланчид” болж, нүүрстөрөгчийн солилцооны олон улсын худалдаанд оролцох боломжтой.

Монгол орны усалгаагүй газар тариалан

Уур амьсгалын өөрчлөлтөд нийцсэн тариалангийн хөрсний ялзмаг, чийг, шим тэжээлийн бодисын менежмент

Субтропикоос өмнө ба умард зүгт орших сэрүүн бүслүүрийн хөрсний ялзмагийн агууламж харьцангуй өндөр тул үржил шим сайтай бөгөөд дэлхийн хүнс үйлдвэрлэлийн томоохон баазад тооцогддог. Монгол орон сэрүүн бүслүүрт багтах хэдий ч Хойд Америк, Зүүн Европ, Сибирь, Хойд Казакстантай харьцуулахад эрс тэс уур амьсгалтай, хур тунадас багатай тул усалгаагүй тариалан эрхлэхэд амаргүй, хөрс, ургамал нь ган болон бусад абиотик стресст өртөмтгий.

Монгол оронд усалгаагүй газар тариаланг цаашид хөгжүүлэхэд хөрсний ялзмагийн агууламжийг сайжруулах асуудалд онцгой анхаарал хандуулах шаардлагатай. Ялзмаг нь эрдэсжих замаар таримал ургамлыг шим тэжээлийн бодисоор хангах, хөрсний катион солилцооны чадавх ба биологийн идэвхийг хангах, хөрсний бүтцийг сайжруулж, элэгдэл, эвдрэлээс хамгаалах зэрэг маш чухал үүргүүдийг гүйцэтгэдэг. Ялзмагаар баялаг хөрс орчны стресст өртөх нь бага, стресс даван туулах чадвар сайтай байдаг.

Иймд усалгаагүй газар тариаланг тогтвортой эрхлэхийн тулд газар тариалангийн үйлдвэрлэлийн менежмент нь хөрсний ялзмагийн агууламжийг нэмэгдүүлэх, тогтворжуулахад чиглэсэн байх ёстой. Өнөөг хүртэл Монгол оронд ашиглагдаж буй зусах “буудай – цулгүй уринш” сэлгээний үршгаар хөрснөөс их хэмжээний органик бодис алдагджээ. Хөрсний органик бодисыг эрдэсжүүлэх, хөрсөнд чийг хуримтлуулах болон хог ургамал устгах

Implemented by



зорилгоор, зусах буудайн тариалангийн талбайн 33 буюу 50 хувийг жил бүр уриншилж байна. Гэтэл Баруун Өмнөд Сибирьт бидний гүйцэтгэсэн судалгаагаар цулгүй уриншийн хөрсөнд чийг хуримтлуулах чадвар үнэн хэрэгтээ тийм ч сайн бус, цомхотгосон буюу тэг элдэншүүлгийг технологийг эзэнт уринш бүхий сэлгээтэй хослуулахад цулгүй уриншаас илүү чийг хуримтлуулдаг болох нь нотлогдсон. Цулгүй уриншийг сэлгээнээс халах тохиолдолд гербицидийн (ялангуяа глифосатын) хэрэглээ нэмэгддэг боловч сэлгээг зөв зохион байгуулах, мэдрэгч бүхий орчин үеийн ухаалаг хор цацагч ашиглах замаар гербицидийн хэрэглээг багасгах боломж бий.

Монголын газар тариаланд хөрсний чийгээс гадна шим тэжээлийн бодисын хомсдол нь ургац хязгаарлах хүчин зүйл болж байна. Шим тэжээлийн бодисын хангамжийг сайжруулснаар ургац нэмэгдэхээс гадна хөрсөнд үлдэх таримлын үлдэгдэл хөрсийг ялзмагаар баяжуулдаг. Түүнчлэн таримал ургамлын калийн хангамж сайжрахад ус ашиглах чадвар нь мөн сайжирдаг.

Байгалийн нөөцийг хэмнэлттэй, тогтвортой ашиглахад чиглэсэн газар тариалангийн менежментийн тогтолцоонд шилжихийн тулд тариаланчид болон холбогдох бусад оролцогч талуудыг анхан шатны болон гүнзгийрүүлсэн сургалтад хамруулах, хөрсний үржил шимийн төлөв байдлын талаар баттай мэдээллийн бааз бүрдүүлэх, тариалангийн техник, технологийг шинэчлэх, үүнд шаардагдах ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх зэрэг ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлагатай. Тариаланчдад уг шилжилтийг амжилттай гүйцэтгэхэд нь татаас, урамшуулал, бага хүүтэй зээл зайлшгүй шаардагдана. Түүнчлэн хөрөнгийн нэмэлт эх үүсвэр бий болгох зорилгоор хөрсөнд нүүрстөрөгч хуримтлуулсан хэмжээндээ дүйцэх квотыг нүүрстөрөгчийн солилцооны олон улсын зах зээлд худалдах боломжийг судлах нь зүйтэй.

Зөвлөмж

- ❖ Монгол орны усалгаагүй газар тариаланд даруй шийдвэрлэх шаардлагатай гол асуудал бол хөрсний ялмагийг хорогдуулж, хөрсийг элэгдэлд өртөмтгий болгож буй үндсэн шалтгаан болох цулгүй уриншийг багасгах явдал юм. Таримлын сэлгээ ашиглах буюу эзэнт уринш бэлтгэх, үүнд ялангуяа буурцагт ургамал тариалах замаар хөрсний ялмагийн агууламж, үржил шимийг нэмэгдүүлж, өвчин, хортон тархалтыг бууруулах боломжтой. Монголд бороо хамгийн их ордог үе нь 7, 8-р сар учраас ургалтын эхэн үедээ чийг харьцангуй бага шаарддаг, харин төгсгөл үедээ чийгийн хэрэгцээ нь нэмэгддэг, эсвэл чийгийн хангамж хэлбэлзэлтэй нөхцөлд дасан зохицсон таримлуудыг сэлгээнд тариалахад тохиромжтой.
- ❖ Сэлгээнд буурцагт ургамал тариалах, үндсэн тарималд зусах арвай, хатуу буудай зэрэг шинэ таримлууд тариалах замаар таримлын сэлгээг баяжуулах нь зүйтэй. Мөн маалинга, наранцэцэг, гурвалжин будааг сэлгээнд тариалж болно. Дээрх таримлуудын селекцийн ажлын үр дүнд ганд тэсвэртэй, Монгол орны нөхцөлд дасан зохицох чадвартай сортууд сүүлийн жилүүдэд шинээр бий болж, үйлдвэрлэлд нэвтрээд буйг судалж, нутагшуулах ажлыг зохион байгуулах нь зүйтэй.
- ❖ Хөрсний чийгийн алдагдлыг бууруулж, ялмагийн агууламжийг нэмэгдүүлэхийн тулд хөрс хамгаалах технологийг мөрдөх зайлшгүй шаардлагатай. Тэг элдэншүүлэг буюу зурваслан тариалах технологийг нэвтрүүлснээр хөрс байнгын хучлагатай байж, ууршилт эрс багасдаг. Хучлагатай хөрсөнд шууд тариалалт хийх, бордоход өмнө нь технологийн хүндрэл учирдаг байсан бол орчин үеийн техникүүд уг асуудлыг бүрэн шийдвэрлэсэн.



- ❖ Таримал ургамлыг ус чийгээс гадна шим тэжээлийн бодисоор хангалттай төвшинд хангах нь хураах ургацаас гадна хөрсөнд үлдэх ургамлын үлдэгдлийг нэмэгдүүлэх тул хөрсний ялзмагийн агууламж, үржил шимийг сайжруулдаг ач холбогдолтой. Бордсон талбайн бичил организмууд хөрсний ургамалд шаардлагатай шим тэжээлийн бодисыг булаацалдах нь багасаж, хөрсний ялзмаг нэмэгдэж, олон эерэг нөлөөг үзүүлдэг.
- ❖ Газар тариаланг мал аж ахуйтай хослуулан хөгжүүлэх нь зүйтэй. Таримлын сэлгээнд тэжээлийн таримал (ялангуяа бүүрцагт ургамал) тариалж малын тэжээлд хэрэглэх, түүнчлэн малын хаягдал бууцаар талбайг бордох замаар хөрсний үржил шимийг сайжруулах нь ихээхэн үр дүнтэй. Уламжлалт мал аж ахуйгаас бууц бэлтгэхэд хүндрэлтэй тул эрчимжсэн маллагаатай фермүүдээс бууц татаж авч хадгалах, талбайд цацахад бэлтгэх, цацах технологийг боловсруулах нь зүйтэй.
- ❖ Дээрх зөвлөмжүүдийг хэрэгжүүлж чадвал тариалангийн хөрснөөс нүүрстөрөгч алдагдах бус харин хөрсөнд хуримтлагддаг тогтолцоо бүрдэх тул Монголын тариаланчид “нүүрстөрөгчийн тариаланч” болж, нүүрстөрөгчийн солилцооны олон улсын худалдаанд оролцох боломжтой болно.

Зохиогчид:

Проф. Др. Георг Гуггенбергер

Др. Ольга Шибистова

Лайбницын нэрэмжит Ханноверын их сургуулийн (LUN) Хөрс судлалын хүрээлэн
Херренхөйзер гудамж - 2
30419 Ханновер
Герман улс

Тайлбар: Энэхүү бодлогын зөвлөмжид багтсан баримт, дүгнэлтийн үнэн зөв байдлыг зохиогч хариуцна. Уг зөвлөмж нь Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” (MNG 19-01) төслийг санхүүжүүлэгч Холбооны Хүнс, хөдөө аж ахуйн яамны албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.